



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/407

Булган сум

Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль, орчныг хамгаалах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 48 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчны холбогдолтой хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалтын зардалд 509,040 (таван зуун есөн мянга дөч) төгрөг зарцуулсугай.

2. Хяналт шалгалтын зардлын 509,040 (таван зуун есөн мянга дөч) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалт хийх төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР